



Сэдэв: Сумдад байгуулагдсан сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, сайжруулах арга зам

Автор: Ч.Мэндэлмаа¹ Т.Өсөхжаргал², Д. Базаррагчаа³ Ш.Мөнхбаатар⁴

^{1, 2, 4} ОБЕГ-ын дэргэдэх ГСХ, ³ОБЕГ, ГЭУГ

Агуулга

Сумдад байгуулагдсан гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд судалгаа, шинжилгээ хийж цаашид эрхзүйн орчныг сайжруулах, үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалтыг бий болгох талаар санал дэвшүүлээ.

Үндэслэл:

Одоогоор 21 аймгийн 268 суманд сайн дурын нийт 268 хэсэг 4876 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд сайн дурын хэсгийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйл ажиллагааг тогтмолжуулах, багаж хэрэгслээр хангах шаардлагатай байна. Тус судалгааны ажлын чиглэлээр урьд өмнө нь хийсэн судалгааны ажил хомс байгаа нь энэхүү судалгаа хийх үндэслэл болж байна.

Сайн дурын ажиллагааны эрхзүйн орчинд хийсэн шинжилгээ

Хүснэгт 1. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааг зохицуулдаг журмын зөрчил, давхардал, хийдэлд хийсэн шинжилгээний дүн


№	Аргачлал	Гамшгаас хамгаалах СДА-ны нийтлэг журам ШС-ын 2018 оны А/24 дугаар тушаал	Гал түймэртэй тэмцэх СДХ ажиллуулах журам ОБЕГ-ын 2015 он А/346 тушаал	Нийт
1.	Давхардал		1	1
2.	Хийдэл		5	5
3.	Зөрчил		1	1
Зөрчил, давхардал, хийдлийн нийлбэр дүн				7

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ




Дорнод аймгийн 3 сумдад тухайн орон нутгийн Засаг дарга “Гамшгаас хамгаалах болон ГТТСДХ” гэж давхардуулан байгуулсан боловч Дорноговь аймгийн СДХ-ээс багаж хэрэгслийн хувьд ялгагдах зүйлгүй байгаа нь энэ журмын хэрэгжилт тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангалт ялгаагүй маш хангалтгүй түвшинд байна. Үүнийг СДХ-ийн хангалт “Гал түймэртэй тэмцэх СДХ ажиллуулах” журмын хавсралтад заасан гал түймэртэй тэмцэх СДХ-т байх гал унтраах зориулалтын автомашин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хангасан үзүүлэлттэй дүйцүүлэн харахад мөн адил маш “хангалтгүй” 70% байгаа нь нийт орон нутгийн СДА-ны хөдөлмөр аюулгүй ажиллагааг хангах хувцас хэрэгсэл хангалтгүй байгааг харуулж байна.

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ




Зураг 2. Дорнод, Дорноговь аймгийн 6 сумын сайн дурын хэсгийн гишүүдийн тоо, дуудлагаар ажилласан байдал




Зураг 3. Сумдын сайн дурын хэсгийн дуудлагаар ажилласан байдал

Сайн дурын үйл ажиллагааг сайжруулах асуудал



14-р зураг. Сайн дурын хэсгийн эрхзүйн орчны өнөөгийн байдал

15-р зураг. Цаашид сайн дурын хэсгийн эрхзүйн орчныг нээмэл болгох санал



Монгол улсын хувьд цаашид гамшгаас хамгаалах сайн дурын нийтлэг журмыг үндэслэн Гамшгаас хамгаалах сайн дурын мэргэшсэн байгууллага эсвэл гамшигтай тэмцэх үндэсний сайн дурын зөвлөлийг байгуулж энэ зөвлөл нь гадаад хамтын ажиллагаа төсөл, хөтөлбөр, бодлого хэрэгжүүлэх болон дотоодын төв орон нутаг дах сайн дурын байгууллагыг идэвхтэй дэмжиж ажилладаг байхаар санал дэвшүүлж байна. Сумын сайн дурын хэсгийн зайлшгүй байвал зохих тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангалтыг нэмэгдүүлж стандартын шаардлагад хүргэх хэрэгтэй.

Эх сурвалж;

Гамшиг судлалын хүрээлэн. Сумдад байгуулагдсан сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдлын судалгаа., УБ., 2020. тайлангийн үр дүнгээс